

## **СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

---

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

### **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

*Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан зайлшгүй нөхцөл,  
шаардлага үүсээгүй байхад аймаг, сумдын төсөвт 3-6 удаа тодотгол  
хийж, орон нутгийн төсвийн орлого, зарлагыг **5,252.1** сая төгрөгөөр  
нэмэгдүүлсэн байна.*

**Сүхбаатар сум  
2018 он**

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b> Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p><b>Дарга, тэргүүлэх аудитор</b> Ч.Энхтуяа</p> <p><b>Аудитын менежер</b> Б.Батмөнх</p> <p><b>Аудитор: А.Дашбат Ц.Уртнасан</b></p> <p><b>2018 оны 04 сар</b></p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442, 70363036 дугаарын утас, <a href="mailto:selenge@audit.gov.mn">selenge@audit.gov.mn</a> хаягаар харилцана уу.</p> <p><b>ХАЯГ:</b>Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд</p>	<p style="text-align: center;"><b>ТАЙЛАНГИЙН АГУУЛГА</b></p> <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b></p> <p><b>Үндсэн мэдээлэл</b></p> <p><b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?</b></p> <p><b>1.1</b> Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?</p> <p><b>1.2</b> Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?</p> <p><b>1.3</b> Төсвийн жилийн дундуур орон нутгийн төсөвт тодотгол хийгдсэн эсэх?</p> <p><b>БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?</b></p> <p><b>2.1</b> Татварын ба татварын бус орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан эсэх?</p> <p><b>2.2</b> Төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байсан эсэх?</p> <p><b>2.3</b> Орон нутгийн төсөвт төвлөрөх орлогыг холбогдох хууль, эрхийн актуудад нийцүүлэн бүрэн төвлөрүүлсэн эсэх?</p> <p><b>БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ БОДИТОЙ БАЙНА УУ?</b></p> <p><b>3.1</b> Батлагдсан төсвийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, зориулалтын дагуу зарцуулсан эсэх?</p> <p><b>3.2</b> Тусгай сан, хөрөнгө оруулалтын батлагдсан зардлыг зориулалтын дагуу, хууль эрхийн актын хүрээнд зарцуулсан эсэх?</p> <p><b>3.3</b> Төсвийн нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх?</p> <p><b>Аудитын дүгнэлт Зөвлөмж Хавсралтууд</b></p>
---	---

## Товчилсон үгийн тайлбар

БСШУС	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга хот, байгуулалтын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХАХНХС	Хүн ам хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
ТЗШБ	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс

# **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

## **1. Аудитын нэр:**

Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэл

## **2. Аудитын код:**

СЭА-2018/01/СТА-ТЕЗ

## **3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

## **4. Аудитын зорилт:**

Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх, гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалган, дүгнэлт, зөвлөмж боловруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршлоо.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн үү?
- Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү?
- Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл бодитой байна уу?

## **5. Аудитын хамрах хүрээ:**

Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн орлого, зарлагыг баталсан аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалыг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

## **6. Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй болон санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, судалгаа хийж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулан дүгнэлт, зөвлөмж, боловсруулав.

## **7. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Төсвийн тухай хууль, 2017 оны Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд, аймгийн ИТХ-ын тогтоолуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

## **8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор А.Дашбат, Ц.Уртнасан нар 2017 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

## **Үндсэн мэдээлэл**

Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого, сумдаас төвлөрүүлэх орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр орон нутгийн төсвийн 52, тусгай шилжүүлгийн 134 байгууллага, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ болон ОНХС зэрэг тусгай сангуудыг санхүүжүүлсэн байна.

2017 онд Монгол Улсын төсөвт 2 удаа тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн төсөвт 3 удаа, сумдын төсөвт тус бүр 3-6 удаа тодотгол хийж, эцсийн дүнгээр нийт орлого, зарлагыг **78,874.5** сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн нийт орлого 101.7 хувь, нийт зарлага 97.4 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

## **БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?**

### **1.1 Сангийн яамнаас хянаж, УИХ-аар батлагдсан ус ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.**

**1.1.1** 2017 оны төсвийн орлогыг Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-д заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн боловсруулжээ.

**1.1.2** Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 2017 оны аймгийн төсвийн урсгал орлогыг 12,245.1 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 11,795.7 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 426.3 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 23.1 сая төгрөгөөр баталсан байна.

**1.1.3** Татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл УИХ-аар батлагдсан хязгаараас нэмэгдүүлэлгүйгээр ХХОАТ-ыг 10,516.9 сая төгрөгөөр, АТӨЯХАТ-ыг 570.0 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийг 129.5 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлогыг 392.7 сая төгрөгөөр баталсан бол ҮХХОАТ-ыг **22.5** сая төгрөгөөр нэмэгдүүлж, 850.0 сая төгрөгөөр, ус ашигласны төлбөрийн орлогыг **331.6** сая төгрөгөөр нэмэгдүүлж, 731.6 сая төгрөгөөр баталсан байна.

2017 оны ус ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яамнаас 400.0 сая төгрөгөөр хянаж, УИХ-аар баталсан ч аймгийн ИТХ-ын 2016 оны 16 дугаар тогтоолоор урьд оны гүйцэтгэлээс 33.8 хувиар, УИХ-аар баталсан хязгаараас 82.9 хувиар тус тус өсгөж, 731,6

сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр **93.8** сая төгрөгөөр тасарсан /ус ашигласны төлбөрийг “Пентатерра” ХХК, “Цемент шохой” ХК гэсэн томоохон компаниуд төлөөгүй/ байна.

**1.1.4** Төсвийн жилийн дундуур буюу аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Хөтөлийн цемент шохой ХК-аас авах ХХОАТ-ын авлага **428.6** сая төгрөгийг тусад нь орлогын зүйл болгон тусгаж, татварын орлогыг нэмэгдүүлэн тодотгосон нь *Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалттай* нийцэхгүй байна.

**1.1.5** Аймгийн татварын бус орлогын хувьд сүүлийн 3 жилийн гүйцэтгэлд үндэслэн хүү торгуулийн орлогыг 150.0 сая төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй бусад орлогыг 229.3 сая төгрөгөөр, төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 47.0 сая төгрөгөөр тус тус баталсан бол төсвийн жилийн дундуур аймгийн Орон нутгийн өмчийн газрын өөрийн орлогыг **8.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 55.0 сая төгрөг болгон тодотгосон байна.

**1.1.6** Зарим сумдын орлогыг хэт багаар төлөвлөснөөс 4 сумын орлого 22,7-63,3 хувиар давж биелсэн байна.

Сумдын орлогын биелэлт, санхүүгийн дэмжлэгийн дүнг **хүснэгт №1-т** харуулбал /Мандал, Ерөө, Хүдэр сумаас татан төвлөрүүлсэн орлого орсон, төсөвт байгууллагын өөрийн орлого ороогүй дүнгээр/: /сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Орлого				Санхүүгийн дэмжлэг
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /% /	Зөрүү	
1	Алтанбулаг	449.80	437.90	97.4	(11.90)	76.70
2	Баруунбүрэн	84.10	125.10	<b>148.8</b>	<b>41.00</b>	<b>309.60</b>
3	Баянгол	326.60	356.30	109.1	29.70	334.40
4	Ерөө	931.70	1,096.50	117.7	164.80	
5	Хүдэр	2,636.00	2,740.90	104.0	104.90	
6	Хушаат	62.80	74.20	118.2	11.40	238.10
7	Жавхлант	69.20	113.00	<b>163.3</b>	<b>43.80</b>	<b>261.60</b>
8	Мандал	2,419.30	2,646.70	109.4	227.40	
9	Орхон	72.60	74.30	102.3	1.70	242.70
10	Орхонтуул	77.90	109.80	<b>140.9</b>	<b>31.90</b>	<b>325.20</b>
11	Сайхан	364.80	447.60	<b>122.7</b>	<b>82.80</b>	<b>221.40</b>
12	Сант	81.00	87.90	108.5	6.90	227.50
13	Шаамар	121.30	123.40	101.7	2.10	407.30
14	Сүхбаатар	590.10	694.80	<b>117.7</b>	<b>104.70</b>	<b>272.70</b>
15	Цагааннуур	106.20	118.30	111.4	12.10	267.30
16	Түшиг	91.90	95.30	103.7	3.40	195.50
17	Зүүнбүрэн	62.00	67.10	108.2	5.10	339.30
	<b>Дүн</b>	<b>8,547.30</b>	<b>9,409.10</b>	<b>110.1</b>	<b>861.80</b>	<b>3,719.30</b>
<b>Аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийн зардлыг бууруулах боломж</b>						<b>304.20</b>

**1.1.7** Дээрх хүснэгтээс дүгнэхэд орлогын төлөвлөгөө 31.9-104.7 сая төгрөгөөр давж биелсэн Сүхбаатар, Сайхан, Орхонтуул, Жавхлант, Баруунбүрэн сумдад аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг уг хэмжээгээр бууруулж, **304.2** сая төгрөг хэмнэх боломжтой байсан байна.

**1.2. Сангийн ямаар хянагдаж, УИХ-аар батлагдсан аймгийн ИТХ-ын урсгал зардлыг аймагт 87.9 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.**

**1.2.1** Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын 2017 оны нийт зарлагыг аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар тогтоолоор **63,130.6** сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

**1.2.2** Сангийн яамнаас аймгийн ИТХ-ын ажлын албаны орон тоог 7 хүнээр тооцож, ИТХ-ын төсвийг 149.7 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн ч орон тоог 2 хүнээр нэмэгдүүлэн, цалин хөлс, НДШ-ийн зардлыг 45.4 сая төгрөгөөр, ИТХ-ын орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг 10.0 сая төгрөгөөр, бусад 11 төрлийн урсгал зардлыг 76.2 сая төгрөгөөр зэрэг нийт **131.6** сая төгрөг буюу 87.9 нэмэгдүүлэн, 281.3 сая төгрөг болгон баталсан байна.

**1.2.3** Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тушаалаар “*Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай*” гэж заасныг зөрчин баяр наадмын зардлыг **65.0** сая төгрөгөөр хэтрүүлэн аймгийн ОНХС-аас 50.0 сая төгрөг, аймаг хөгжүүлэх сангаас 25.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

**1.2.4** Төсвийн тухай хуулийн 29.4-д “*Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана*” гэж заасныг зөрчин зураг төсөв хийгдээгүй **400.0** сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан байна. **Үүнд:**

- *Мандал сумын Түнхэл тосгонд сургуулийн дотуур байр худалдан авах 200.0 сая төгрөг;*
- *Аймгийн төвд сүрьеэгийн эмнэлгийн барилга худалдан авах 200.0 сая төгрөг.*

**1.2.5** “Болд төмөр Ерөө гол” ХХК-ийн хандивын **95.0** сая төгрөгөөр аймгийн төвд баригдсан хөлбөмбөгийн талбайн ажил чанаргүй хийгдэж, ашиглах боломжгүй болсон учир шинээр стандарт таримал зүлэгтэй хөлбөмбөгийн талбайг аймгийн ОНХС-гийн **327.0** сая төгрөгийн эх үүсвэрээр барихаар төлөвлөсөн нь аймаг, орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтад тавигдах мэргэжлийн байгууллагын хяналт сул, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулж буйг харуулж байна.

**1.2.6** Аймаг хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг аймгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон батлаагүй атал аймгийн Засаг даргын 2017 оны 01-р сарын 23-ны өдрийн А/38 дугаар захирамжаар 23,4 сая төгрөг зарцуулах шийдвэр гаргасан бол төсвийн жилийн дундуур аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 92 дугаар тогтоолоор аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн баяр наадмын зардалд тус сангаас **25.0** сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн нь Төсвийн тухай хуулийн 18.5 дахь “ ...*орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**1.2.7** Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь “*Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх*” гэсэн заалтыг зөрчин аймаг, сумын төсвөөс улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардалд нийт **114.3** сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна. **Үүнд:**

#### **Аймгийн төсвийн хөрөнгөөр:**

- *Аймгийн Прокурорын газарт архивын шүүгээ худалдан авахад 4.8 сая төгрөг;*
- *Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авахад 25.0 сая төгрөг;*
- *Хилийн цэргийн 0101-р ангийн урсгал засварт 9.5 сая төгрөг.*
- *Алтанбулаг дахь Гаалийн шалган нэвтрүүлэх байрны нийтийн бие засах өрөөний тохижилтод 40.0 сая төгрөг;*
- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны уулзалтын өрөөг тохижуулахад 5.0 сая төгрөг.*

#### **Сумын төсвийн хөрөнгөөр:**

- *Мандал сумын орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас Мандал сум дахь Онцгой байдлын хэлтэст Зил-131 машин худалдан авахад 20.0 сая төгрөг;*
- *Шаамар сумын ИТХ-ын төсвөөс аймгийн Цагдаагийн газрын мэдүүлэг авах тусгайлан бэлдсэн өрөөг засварлахад шаардлагатай 10.0 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.*

**1.3 Аймгийн төсөвт 3 удаа, сумдын төсөвт 2-6 удаа тодотгол хийгдсэн байна.**

**1.3.1** Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 2017 оны орон нутгийн нийт орлого, зарлагын төлөвлөгөөг УИХ-аас батлагдан ирсэн төсвийн хязгаараас 416.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 63,130.6 сая төгрөгөөр баталсан байна.

**1.3.2** Төсвийн жилийн дундуур аймгийн төсөвт 3 удаа тодотгол хийсэн бөгөөд төсвийн өөрчлөлтийг тодотгол тус бүрээр **хүснэгт №2-т** харуулбал: /сая төгрөгөөр/



№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2017 он				Аймаг, сумын нээгээсэн тодотгосон төсөв
			Анх батлагдсан	Тодотгол-1	Тодотгол-2	Тодотгол-3	
А	Б	1	2	3	4	5	
	<b>ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар</b>		2016.12.02 №16	2017.05.05 №21	2017.11.14 №33	2017.12.01 №35	
	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО</b>	<b>11,768.6</b>	<b>12,222.0</b>	<b>12,929.7</b>	<b>12,740.4</b>	<b>12,771.2</b>	<b>21,604.5</b>
А	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>62,674.1</b>	<b>63,130.6</b>	<b>64,132.3</b>	<b>67,501.0</b>	<b>67,481.8</b>	<b>78,874.5</b>
1	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>11,768.6</b>	<b>12,222.0</b>	<b>12,929.7</b>	<b>12,740.4</b>	<b>12,771.2</b>	<b>21,604.5</b>
1.1	Татварын орлого	11,401.6	11,795.7	12,503.4	12,311.8	12,336.8	19,719.0
1.2	Татварын бус орлого	367.0	426.3	426.3	428.6	434.4	1,885.5
2	<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>20.0</b>	<b>23.1</b>	<b>23.1</b>	<b>23.1</b>	<b>23.1</b>	<b>23.1</b>
3	<b>УЛСЫН ТӨСӨВ ОРОН НУТГИЙН ТӨСӨВ ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,885.5</b>	<b>50,885.5</b>	<b>49,497.2</b>	<b>52,683.1</b>	<b>52,633.1</b>	<b>52,633.1</b>
4	<b>СУМЫН ТӨСВӨӨС АЙМГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО</b>			<b>857.8</b>	<b>1,207.8</b>	<b>1,207.8</b>	
5	Урьд оны үлдэгдэл /урсгал/			<b>690.0</b>	<b>712.1</b>	<b>712.1</b>	<b>2,711.8</b>
6	Урьд оны үлдэгдэл /ОНХС/			<b>134.5</b>	<b>134.5</b>	<b>134.5</b>	<b>134.5</b>
7	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх төлбөрийн орлого						<b>1,767.5</b>
	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА</b>	<b>11,768.6</b>	<b>12,222.0</b>	<b>13,619.7</b>	<b>13,452.5</b>	<b>13,483.3</b>	<b>24,316.3</b>
Б	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>62,674.1</b>	<b>63,130.6</b>	<b>64,132.3</b>	<b>67,501.0</b>	<b>67,481.8</b>	<b>78,874.5</b>
1	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>58,985.5</b>	<b>59,442.0</b>	<b>59,289.6</b>	<b>62,597.9</b>	<b>62,578.7</b>	<b>69,498.5</b>
1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,364.9	47,629.5	47,651.5	50,475.2	50,422.9	55,346.4
1.2	ХҮҮ /ТЗШилжүүлэг/						
1.3	ТАТААС	149.1	153.8	246.9	246.9	246.9	825.6
1.4	ШИЛЖҮҮЛЭГ	11,471.5	11,658.7	11,391.2	11,875.8	11,908.9	13,326.5
2	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,688.6</b>	<b>3,688.6</b>	<b>4,842.7</b>	<b>4,903.1</b>	<b>4,903.1</b>	<b>7,672.9</b>
3	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-				<b>1,703.1</b>
В	<b>УРСГАЛ ТЭНЦЭЛ</b>	<b>(47,216.90)</b>	<b>(47,220.00)</b>	<b>(46,359.90)</b>	<b>(49,857.50)</b>	<b>(49,807.50)</b>	<b>(47,894.00)</b>
	<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	-	-	-	-	-

**1.3.3** Тайлант жилийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл аймгийн төсөвт 712.1 сая төгрөг, сумдын төсөвт 1,999.7 сая төгрөгөөр тайлагнагдсан нь аймаг, сумдын төсвийн алдагдлыг нөхөх эх үүсвэр болж, төсвийн суурь зарлага мөн хэмжээгээр өсөхөд нөлөөлсөн байна.

**1.3.4** Тайлант онд аймгийн төсөвт хийгдсэн тодотголуудаар орлого талд гарсан гол өөрчлөлтүүдийг дурдвал:

- Хүдэр, Мандал, Ерөө сумдаас нийт 1,207.8 сая төгрөгийн орлогыг татан төвлөрүүлсэн.
- Урьд оны төсвийн үлдэгдэл 712.1 сая төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 134.5 сая төгрөгөөр орлого нэмэгдүүлсэн.
- Татварын буцаан олголт хэмнэлт 279.0 сая төгрөгөөр орлого нэмэгдүүлсэн.
- Хөтөлийн цемент шохой ХК-аас авах татварын авлагын 262.1 сая төгрөгийг бараа материалаар авахаар орлого нэмэгдүүлсэн.
- ХХОАТ-ын орлогыг 25.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Зарлага талд гарсан гол өөрчлөлтүүдийг дурдвал:

- *Аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 2 удаагийн тодотголоор 35.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.*
- *Аймгийн ЗДТГ-ын урсгал зардлыг 2 удаагийн тодотголоор 159.8 сая төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгийг 331.3 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид олгох төсвийн татаасыг 93.1 сая төгрөгөөр, Санхүүгийн хяналт, аудитын албаны урсгал зардлыг 13.8 сая төгрөгөөр, БОАЖГ-ын урсгал зардлыг 12.0 сая төгрөгөөр, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 87.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.*
- *Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал 51.8 сая төгрөг, аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн зардлыг 25.0 сая төгрөг, өвс тэжээлийн нөөц бэлтгэлийн зардлыг 108.4 сая төгрөг, цаг уурт зориудаар нөлөөлөх арга хэмжээний зардал 30.0 сая төгрөгийг тус тус нэмж тодотгосон.*
- *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 1,687.5 сая төгрөгөөр, замын сангийн хөрөнгө оруулалтыг 428.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.*

**1.3.5** Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчин зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт нийт **5,252.1** сая төгрөгийн тодотгол хийсэн байна. **Үүнд:**

- *Тайлант онд 14 сум тус бүр 3-6 удаа төлөвлөгөөнөөс давсан орлогыг тодотгон, орон нутгийн байгууллагуудын урсгал зардалд 533.2 сая төгрөгийг, хөрөнгө оруулалтын зардалд 3,082.5 сая төгрөгийг зэрэг нийт **3,615.7** сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан.*
- *Аймгийн төсвийн орлогыг “Хөтөлийн цемент шохой” ХК-аас авах **428.6** сая төгрөгийн ХХОАТ-ын авлага, Мандал, Ерөө, Хүдэр сумдаас татан төвлөрүүлсэн **1,207.8** сая төгрөгийн орлогоор тус тус нэмэгдүүлэн тодотгож, хөрөнгө оруулалтын болон урсгал зардлуудад хуваарилан баталсан байна.*

Иймд цаашид Төсвийн тухай хуулийн 34.1-д заасан зайлшгүй нөхцөл, шалтгаан үүссэнээс бусад тохиолдолд төсөвт тодотгол хийхгүй байх нь зүйтэй юм.

## **БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?**

**2.1. Аймаг ус ашигласны төлбөрийн орлогыг, зарим сумд хог хаягдлын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх нөөц боломжийг бүрэн ашиглаагүй байна.**

**2.1.1** Аймаг, сумдын орон нутгийн төсвийн орлого 21,503.1 сая төгрөгөөр батлагдсанаас 23,692.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна. Үүнийг хүснэгт №3-т харуулбал:

/сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл		
		Аймгийн орлого	Сумдын орлого	Төсвийн нийт орлого

		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Урсгал орлого</b>	<b>18,497.0</b>	<b>12,771.2</b>	<b>14,057.6</b>	<b>8,708.7</b>	<b>9,580.9</b>	<b>21,480.0</b>	<b>23,638.5</b>	<b>2,158.5</b>	<b>110.0</b>
<b>Татварын орлого</b>	<b>16,537.1</b>	<b>12,336.9</b>	<b>13,165.5</b>	<b>7,382.1</b>	<b>7,936.8</b>	<b>19,719.0</b>	<b>21,102.3</b>	<b>1,383.3</b>	<b>107.0</b>
Хүн амын орлогын албан татвар	9,761.2	9,663.0	10,407.5	970.6	1,280.0	10,633.6	11,687.5	1,053.9	109.9
Өмчийн татвар	978.2	850.0	971.8	0.0	0.0	850.0	971.8	121.8	114.3
Бараа үйлчилгээний албан татвар	5,797.7	1,823.9	1,786.2	6,411.5	6,656.8	8,235.4	8,443.0	207.6	102.5
<b>Татварын бус орлого</b>	<b>1,959.9</b>	<b>434.3</b>	<b>892.1</b>	<b>1,326.6</b>	<b>1,644.1</b>	<b>1,761.0</b>	<b>2,536.2</b>	<b>775.2</b>	<b>144.0</b>
Татварын бус орлого	1,506.7	379.3	802.9	1,165.2	1,472.5	1,544.5	2,275.4	730.9	147.3
Өөрийн орлого	453.2	55.0	89.2	161.4	171.6	216.5	260.8	44.3	120.5
<b>Хөрөнгө борлуулсны орлого</b>	<b>152.3</b>	<b>23.1</b>	<b>53.5</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>23.1</b>	<b>53.5</b>	<b>30.4</b>	<b>231.6</b>
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>18,649.3</b>	<b>12,794.3</b>	<b>14,111.1</b>	<b>8,708.7</b>	<b>9,580.9</b>	<b>21,503.1</b>	<b>23,692.0</b>	<b>2,188.9</b>	<b>110.2</b>

**2.1.2** Аймгийн дүнгээр хүн амын орлогын албан татвар 1,053.9 сая төгрөгөөр, өмчийн татвар 121.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний албан татвар 207.6 сая төгрөгөөр, татварын бус орлого 730.8 сая төгрөгөөр, өөрийн орлого 44.3 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 30.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэн байна.

**2.1.3** Алтанбулаг сумын орлогын төлөвлөгөө 5.1 сая төгрөгөөр тасарч, бусад 16 сум болон аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2.3-223.2 сая төгрөгөөр давж биелсэн байна. /Аймаг, сумдын орлогын гүйцэтгэлийг хавсралт-1-д үзүүлэв/

**2.1.4** Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээр биелсэн боловч нэр төрлөөр нь авч үзэхэд ус ашигласны төлбөрийн орлого 93.8 сая төгрөгөөр тасарсан байна. Усны төлбөрийн орлого тасарсан шалтгааныг авч үзвэл:

- “Пентатерра” ХХК 117.4 сая төгрөгийн, “Цемент шохой” ХК 123.3 сая төгрөгийн усны төлбөрийг төлөөгүй нь уг орлого тасрахад голлон нөлөөлсөн байна.

**2.1.5** Дуудлага худалдаагаар борлуулсан хөрөнгийн орлогыг 1.4 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Мандал сумын Цагдаагийн хэлтэст бүртгэлтэй байсан /Хонда HR-V/ авто машиныг 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 81 тоот гэрээ байгуулан борлуулсан ч 0.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй;
- “Газшгай-Ус” ХХК-д бүртгэлтэй байсан /УАЗ-469/ авто машиныг 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулан 0.7 сая төгрөгөөр борлуулсан ч орлогыг төвлөрүүлээгүй.

- *Баянгол сумын ЗДТГ-т бүртгэлтэй байсан /Ланд крузер 80/ авто машиныг 2017 оны 08 дугаар сард дуудлага худалдаагаар 1.2 сая төгрөгөөр борлуулсан ч 0.5 сая төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн байна.*

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 5-д “Худалдан авагч нь дуудлагын худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө”, 6-д “Хэрэв ялагч нь төлбөрийг заасан хугацаанд эс төлбөл уг эд хөрөнгийг өөрийн санал болгосон үнээр худалдан авах эрх дуудлага худалдаанд удаахь үнэ санал болгосон оролцогчид шилжинэ. Уг оролцогч төлбөрийг 14 хоногийн хугацаанд төлнө” гэж заасныг зөрчсөн байна.


**2.1.6** Сумдын хувьд төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзэхэд хог хаягдлын хураамж 97.4 сая төгрөгөөр, татварын бус бусад орлого 29.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 24.6 сая төгрөгөөр, агнуурын нөөц ашгласны төлбөр 12.1 сая төгрөгөөр, хөрөнгийн хөдлөх эрхийн орлогыг 1.6 сая төгрөгөөр, бууны албан татвар 1.1 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр 1.0 сая төгрөгөөр, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр, түрээсийн орлого 0.1 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Сумдын төсвийн зарим орлого тасарсан шалтгааныг авч үзэхэд:

- *Алтанбулаг суманд Хот тохижуулах газар шинээр байгуулж, санхүүжүүлэхээр хог хаягдлын хураамжийн орлогыг 99.6 сая төгрөгөөр буюу хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалж уг орлогын төлөвлөгөө 57.1 сая төгрөгөөр тасарсан бол Сүхбаатар суманд Цахилгаан шугам сүлжээний газартай байгуулсан гэрээг цуцалж, 2017 оны 1-10 сар хүртэл байцаагч нар хэрэглэгчид хүрч ажиллаж чадаагүйгээс 27.6 сая төгрөгөөр, Мандал сумын ААНБ-ууд сумын ИТХ-аас гаргасан гаргасан үнэ тарифын дагуу төлбөр хураамжаа төлөөгүй, гэр хорооллын айл өрхүүдийн дөнгөж 5.9 хувь нь хог тээвэрт хамрагдсантай холбоотой 10.3 сая төгрөгөөр, иргэдээс авах төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлээгүйгээс Хушаат сум 4.5 сая төгрөгөөр, Зүүнбүрэн сум 1.3 сая төгрөгөөр гэх зэрэг нийт 100.8 сая төгрөгөөр хог хаягдлын хураамжийн орлогыг тасалсан байна.*
- *Үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурснаас шалтгаалан хөрөнгийн хөдлөл, эрхийн орлогыг Баруунбүрэн сум 0.6 сая төгрөгөөр, Ерөө сум 0.3 сая төгрөгөөр, Хүдэр сум 0.6 сая төгрөгөөр, Хушаат сум 0.9 сая төгрөгөөр, Мандал сум 2.4 сая төгрөгөөр, Орхон сум 0.2 сая төгрөгөөр, Орхонтуул сум 0.4 сая төгрөгөөр, Сайхан сум 1.7 сая төгрөгөөр, Цагааннуур сум 1.4 сая төгрөгөөр, Түшиг сум 0.3 сая төгрөгөөр гэх зэрэгнийг 8.8 сая төгрөгөөр тасалсан байна.*

**2.2 Орон нутгийн өмчийг ашиглан халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниудаас 138.7 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэх нөөц боломж байна.**

**2.2.1** Орон нутгийн төсөвт байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг 120.5 хувиар буюу 44.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг 5.8 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр тасалсан байна. /Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт-2-т үзүүлэв/

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг **график 1**-ээр харуулбал:



**2.2.2** Орон нутгийн байгууллагуудаас Алтанбулаг, Баянгол, Ерөө, Жавхлант, Мандал, Орхон, Орхонтуул, Сант, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Цагааннуур сумдын ЗДТГ, Түнхэл тосгоны захирагчийн алба, Цагааннуур сумын Ойн анги зэрэг байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг нийт **44.3** сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-т үзүүлэв./

**2.2.3** Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудаас Баруунбүрэн сумын спорт цогцолбор, соёлын төв, Мандал сумын МХДБЧуулга, Спорт сургалтын цогцолбор, Хэрх тосгоны соёлын төв, Түнхэл тосгоны соёлын төв зэрэг байгууллагууд нийт 1.7 сая төгрөгөөр өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

**2.2.4** Түшиг сумын ЗДТГ нь бусдад байр түрээслүүлдэг хэдий ч түрээсийн орлогыг төлөвлөж батлуулаагүй байхад гүйцэтгэлээр 4.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Цаашид Түшиг сумын ЗДТГ-ын түрээсийн орлогыг бодит байдалд нийцүүлэн төлөвлөж, батлуулах шаардлагатай юм.

**2.2.5** Сумдын төр, төсвийн байгууллагуудад халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниуд төрийн өмчийн барилга, байгууламжийг ашиглан, үйл ажиллагаа явуулж байгаа боловч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 28 дугаар зүйлийн 28.5-д заасны дагуу түрээсийн төлбөр төлж байгаагүй байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан түрээсийн төлбөрийн жишиг үнийн дагуу түрээсийн орлогын тооцооллыг **хүснэгт № 4-т** тооцож үзэхэд багаар бодоход **138.7** сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжтой байна.

№	Сумын нэр	Халаалтын компанийн нэр	Халаалтын компанийн ашиглаж байгаа объект аль байгууллагын бүртгэлд байдаг талаар	Талбайн хэмжээ /М2/	м2-н үнэ	Түрээсийн орлого /сая төгрөг/	Халаалтын 7 сард	Одоо авч байгаа сумдын орлого халаалтын 7 сараар	Нэмэгдүүлэх боломжтой орлогын дүн
1	Баянгол	Ануужээ ХХК	ЗДТГазар	750	5000	<b>3,750,000.00</b>	<b>26,250,000.00</b>		<b>26,250,000.00</b>
2	Ерөө	Монжимтрейд ХХК	ЗДТГазар	15	5000	75,000.00	525,000.00		525,000.00
		Монжимтрейд ХХК	ЕБСургууль	135	5000	675,000.00	4,725,000.00		<b>4,725,000.00</b>
		Монжимтрейд ХХК	Цэцэрлэг	21.4	5000	107,000.00	749,000.00		<b>749,000.00</b>
		Монжимтрейд ХХК	Соёлын Төв, спорт цогцолбор	30	5000	150,000.00	1,050,000.00		<b>1,050,000.00</b>
		Монжимтрейд ХХК	ЭМТөв	36	5000	180,000.00	1,260,000.00		1,260,000.00
<b>Ерөө сум нэгтгэл</b>						<b>4,937,000.00</b>	<b>34,559,000.00</b>		<b>34,559,000.00</b>
3	Жавхлант	Монжимтрейд ХХК	ЗДТГазар	20	5000	100,000.00	700,000.00		700,000.00
		Монжимтрейд ХХК	Дунд сургууль	58	5000	290,000.00	2,030,000.00		2,030,000.00
		Монжимтрейд ХХК	Цэцэрлэг	42	5000	210,000.00	1,470,000.00		1,470,000.00
		Монжимтрейд ХХК	Соёлын төв	30	5000	150,000.00	1,050,000.00		1,050,000.00
		Монжимтрейд ХХК	ЭМТөв	10	5000	50,000.00	350,000.00		350,000.00
<b>Жавхлант нийт дүн</b>						<b>800,000.00</b>	<b>5,600,000.00</b>		<b>5,600,000.00</b>
4	Зүүнбүрэн	Монжимтрейд ХХК	Орон нутгийн өмч	55	5000	<b>275,000.00</b>	<b>1,925,000.00</b>		<b>1,925,000.00</b>
5	Мандал	Арвижих өргөө ХХК	Хэрх соёлын төв	152	5000	760,000.00	5,320,000.00		5,320,000.00
		Хэрх илч ХХК	Хэрх захирагчийн алба	500	5000	2,500,000.00	17,500,000.00		17,500,000.00
		Түнхэл дулаан ХХК	Түнхэл захирагчийн алба	112.5	5000	562,500.00	3,937,500.00		3,937,500.00
<b>Мандал сум нэгтгэл</b>						<b>3,822,500.00</b>	<b>26,757,500.00</b>		<b>26,757,500.00</b>
6	Сант	Бүрэндулаан ХХК	ЕБСургууль	54	5000	<b>270,000.00</b>	<b>1,890,000.00</b>		<b>1,890,000.00</b>
7	Цагааннуур	Атар трейд ХХК	Сумын ЗДТГ	174.6	5000	<b>873,000.00</b>	<b>6,111,000.00</b>	3,666,600.00	<b>2,444,400.00</b>
8	Хушаат	Монжимтрейд ХХК	ЗДТГазар	78.4	5000	392,000.00	2,744,000.00		2,744,000.00
		Монжимтрейд ХХК	ЕБСургууль	65	5000	325,000.00	2,275,000.00		2,275,000.00
		Монжимтрейд ХХК	ЭМТөв	27.04	5000	135,200.00	946,400.00		946,400.00
		Монжимтрейд ХХК	Цэцэрлэг	30.8	5000	154,000.00	1,078,000.00		1,078,000.00
		Монжимтрейд ХХК	Соёлын төв	24.7	5000	123,500.00	864,500.00		864,500.00
<b>Хушаат сум нэгтгэл</b>						<b>2,272,700.00</b>	<b>15,908,900.00</b>		<b>15,908,900.00</b>
9	Хүдэр	Хүдэр дулаан ХХК	ЗДТГазар	288	5000	<b>1,440,000.00</b>	<b>10,080,000.00</b>		<b>10,080,000.00</b>
10	Шаамар	Алтанбилэг ХХК	Шаамар сум	180	5000	900,000.00	6,300,000.00		6,300,000.00
		Алтанбилэг ХХК	Дулаанхаан тосгон	200	5000	1,000,000.00	7,000,000.00		7,000,000.00
<b>Шаамар сум нэгтгэл</b>						<b>1,900,000.00</b>	<b>13,300,000.00</b>		<b>13,300,000.00</b>
<b>Нийт дүн</b>				<b>1,321.6</b>		<b>20,340,200.00</b>	<b>142,381,400.00</b>	<b>3,666,600.00</b>	<b>138,714,800.00</b>

**2.2.6** Аудитын явцад тулган баталгаажуулалт хийж үзэхэд өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, орлого дутуу төвлөрүүлсэн зэрэг нийт **20.0** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. **Үүнд:**

- *ЭМТ-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэх эмийн сангийн борлуулалтын орлогыг Түшиг сумын ЭМТ 3.5 сая төгрөгөөр, Хүдэр сумын ЭМТ 5.4 сая төгрөгөөр, нийт 8.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;*
- *Өөрийн орлогын төлөвлөгөөг аймгийн ЗДТГ 2.6 сая төгрөгөөр, Сэлэнгийн долгио чуулга 2.5 сая төгрөгөөр, аймгийн номын сан 0.1 сая төгрөгөөр, Баянгол сумын Спорт цогцолбор 1.0 сая төгрөгөөр, Соёлын төв 0.8 сая төгрөгөөр, Цагааннуур сумын спорт цогцолбор 1.3 сая төгрөгөөр, Сайхан сумын спорт клуб 1.5 сая төгрөгөөр, Орхон сумын соёлын төв 0.8 сая төгрөгөөр, Орхонтуул сумын соёлын төв 0.7 сая төгрөгөөр, нийт 11.3 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.*

**2.3 Аймгийн төсөвт төвлөрөх орлогыг холбогдох хууль, эрхийн актуудад нийцүүлэн бүрэн төвлөрүүлээгүй байна.**

**2.3.1** Зарим сумд Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь заалтыг зөрчин улс, аймгийн төсөвт төвлөрөх орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэн байна. **Тухайлбал:**



- Баянгол сумын ЗДТГ нь Цагдаагийн хэсгийн өөрийн орлого болох Цагдаагийн хэсгийн журмын хашааны орлогын 6.4 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан байна.
- Аймгийн төсөвт төвлөрүүлэх хадлангийн газрын төлбөрийг Баянгол сум 7.0 сая төгрөгийг, Ерөө сум 9.2 сая төгрөгийг, Орхонтуул сум 0.5 сая төгрөгийг, Шаамар сум 1.1 сая төгрөгийг гэх зэрэг нийт 17.8 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлсэн байна.

### БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ БОДИТОЙ БАЙНА УУ?

**3.1 Орон нутгийн төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад батлагдсан төсвийг зориулалт бусаар, үрэлгэн зарцуулах, холбогдох хууль, тогтоомжийг зөрчин хөрөнгө зарцуулах зэрэг их хэмжээний зөрчил оршиж байна.**

**3.1.1** Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн нийт зарлага тодотгосон төсвөөр 78,874.5 сая төгрөгөөр батлагдсанаас 76,839.4 сая төгрөгийг зарцуулж, 97.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 2,035.1 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна. Энэ нь өмнөх оны зарлагын гүйцэтгэлээс 9.2 хувиар өссөн бөгөөд төсвийн нийт зарлагын 39.2 хувийг орон нутгийн төсөвт байгууллагуудын зардал, 60.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардал эзэлж байна.

Нийт зарлагын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар задалж **хүснэгт №5-д** харуулбал: /сая төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв /2/	Гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=4-3
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>70,347.90</b>	<b>63,130.60</b>	<b>78,874.50</b>	<b>76,839.40</b>	<b>(2,035.10)</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>63,312.00</b>	<b>59,442.00</b>	<b>69,498.50</b>	<b>69,047.60</b>	<b>(450.90)</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>52,103.10</b>	<b>47,629.50</b>	<b>55,346.40</b>	<b>54,922.60</b>	<b>(423.80)</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	32,619.60	32,586.50	33,241.50	33,194.20	(47.30)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,575.80	3,604.70	3,685.40	3,675.80	(9.60)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,205.60	6,058.30	7,464.70	7,430.10	(34.60)
2104	Хангамж, бараа материалын зардал	1,222.00	1,087.10	1,418.20	1,407.20	(11.00)
2105	Нормативт зардал	2,958.10	2,063.30	3,059.50	3,055.50	(4.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	641.50	207.00	1,325.70	1,331.40	5.70
2107	Томилот, зочны зардал	211.50	153.10	247.60	242.90	(4.70)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,281.60	711.00	1,528.00	1,445.00	(83.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,387.40	1,158.50	3,375.80	3,140.50	(235.30)
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>572.20</b>	<b>153.80</b>	<b>825.60</b>	<b>823.70</b>	<b>(1.90)</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	194.90	75.10	168.20	168.20	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	377.30	78.70	657.40	655.50	(1.90)
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,636.70</b>	<b>11,658.70</b>	<b>13,326.50</b>	<b>13,301.30</b>	<b>(25.20)</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	197.50	111.00	108.00	108.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,439.20	11,547.70	13,218.50	13,193.30	(25.20)
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,159.30</b>	<b>3,688.60</b>	<b>7,672.90</b>	<b>7,331.90</b>	<b>(341.00)</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>876.60</b>		<b>1,703.10</b>	<b>459.90</b>	<b>(1,243.20)</b>

**3.1.2** Орон нутгийн төсвийн нийт зардал 32,105.5 сая төгрөгөөр батлагдсанаас 30,106.6 сая төгрөг буюу 93.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бөгөөд нийт зардлын 74.1 хувийг урсгал зардал, 25.9 хувийг хөрөнгө оруулалтын зардал, эргэж төлөгдөх зээлийн дүн эзэлж байна.

**3.1.3** Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн нийт зардал 46,769.0 сая төгрөгөөр батлагдсанаас 46,732.8 сая төгрөгийн буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нийт зарлагын 86.8 хувийг БСШУСайдын, 12.0 хувийг ЭМСайдын, 0.5 хувийг БХБСайдын, 0.7 хувийг ХАХНХСайдын багцын байгууллагууд эзэлж байна.

**Орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэлийн бүтцийг график 2-т харуулбал:**



**3.1.4** Дээрх графикаас харахад нийт төсвийн зарлагын 48.0 хувийг цалин, шимтгэлийн зардалд, 9.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 4.0 хувийг нормативт зардалд, 1.1 хувийг татаас, 17.3 хувийг урсгал шилжүүлгийн зардалд, 9.5 хувийг хөрөнгийн зардалд, 10.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

**3.1.5** Төсвийн нийт зарлагын хэмнэлтэд орон нутгийн болон ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл сангийн зарлага, бусад бараа үйлчилгээний зардлын хэмнэлт нөлөөлсөн байна. **Хүснэгт № 6-д** үзүүлэв:

/сая төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт/-/, хэтрэлт/+/
<b>1.Орон нутаг</b>	<b>32,105.5</b>	<b>30,106.6</b>	<b>-1,998.9</b>
<i>Үүнээс: Бараа ажил үйлчилгээний зардал</i>	<i>13,452.8</i>	<i>13,060.0</i>	<i>-392.8</i>
<i>Татаас</i>	<i>430.7</i>	<i>428.7</i>	<i>-2.0</i>
<i>Урсгал шилжүүлгийн зардал</i>	<i>8,846.0</i>	<i>8,826.1</i>	<i>-19.9</i>
<i>Хөрөнгийн зардал</i>	<i>7,672.9</i>	<i>7,331.9</i>	<i>-341.0</i>



Төсөл сан	1,703.1	459.9	-1,243.2
<b>2.Тусгай шилжүүлэг</b>	<b>46,769.0</b>	<b>46,732.8</b>	<b>-36.2</b>
<b>ОРОН НУТГИЙН НИЙТ</b>	<b>78,874.5</b>	<b>76,839.4</b>	<b>-2,035.1</b>

**3.1.6** Дээрх хүснэгтээс дүгнэхэд нийт төсвийн хэмнэлтийн 61.1 хувийг эзэлж байгаа сум хөгжүүлэх сангийн зарцуулалт нь гүйцэтгэлээр хэмнэлттэй харагдаж байгаа ч иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт удаашралттай байгаатай холбоотой эх үүсвэрийн дутагдлаас шалтгаалсан байна.

**3.1.7** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалтуудыг бүрэн мөрдөөгүйгээс батлагдсан төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал:

- Батлагдсан орон тоог хэтрүүлснээс аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, Жавхлант сумын Соёлын төв, Орхонтуул сумын ЗДТГ, цэцэрлэг, Түшиг сумын ЭМТ, Хүдэр сумын цэцэрлэг, Хушаат сумын цэцэрлэг, Цагааннуур сумын ЗДТГ зэрэг 8 байгууллага нийт **22.9** сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гаргасан;
- Баянгол сумын Соёлын төв, Хушаат сумын цэцэрлэгүүд батлагдсан цалингийн төсвийг **1.2** сая төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан;
- Зүүнбүрэн сумын ЭМТ, Жавхлант сумын ЕБС, Мандал сумын Ачит багийн өрхийн эмнэлэг, Хэрх, Түнхэл тосгоны соёлын төв, Орхонтуул сумын соёлын төв, Сант сумын ЕБС, Сайхан сумын ИТХ, Сүхбаатар сумын өрхийн эмнэлэг, 6-р сургууль, Хүдэр сумын ЗДТГ, Цагааннуур сумын ЕБС зэрэг 12 байгууллага хууль эрхзүйн үндэслэлгүйгээр нийт **9.1** сая төгрөгийн цалин илүү бодож олгосон;
- Аймгийн ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Алтанбулаг сумын 1, 2-р цэцэрлэг, Бугант тосгоны Захирагчийн алба, Зүүнбүрэн сумын соёлын төв, Орхонтуул сумын 1, 2-р ЕБС, цэцэрлэг, Түшиг сумын ЕБС, ЭМТ, Хүдэр сумын ЕБС, Шаамар сумын ЕБС, соёлын төв, Дулаанхаан тосгоны ЕБС, соёлын төв, Сайхан сумын ЕБС зэрэг 17 байгууллага үр дүнгийн урамшууллыг давхардуулан нийт **33.3** сая төгрөг олгосон;
- Ерөө сумын Сум дундын ойн анги, Бугант тосгоны Захирагчийн алба, ЭМТ, Мандал сумын ЗДТГ, 1-р цэцэрлэг, Мөнгөн хараа чуулга, Түнхэл тосгоны ЭМТ, Сүхбаатар сумын ЗДТГ, Хүдэр сумын ЗДТГ, ЕБС, цэцэрлэг, Хушаат сумын ЗДТГ, ЭМТ, цэцэрлэг, Цагааннуур сумын ИТХ, ЕБС, цэцэрлэг зэрэг 17 байгууллага ээлжийн амралттай хугацаанд нийт **11.9** сая төгрөгийн цалин давхардуулан олгосон;
- Аймгийн ГХБХБГазар, Сэлэнгийн долгио чуулга, Жавхлант сумын ЕБСургууль, цэцэрлэг, Орхон сумын ИТХ, Орхонтуул сумын ЕБСургууль, цэцэрлэг, Рашаант тосгоны ЕБС, ЭМТ, Сант сумын ЕБС, Сайхан сумын 24-р цэцэрлэг, Сүхбаатар сумын 3, 4, 6-р сургууль, 1, 7-р цэцэрлэг, Хүүхдийн сувилал, Шаамар сумын ИТХ, ЕБС, цэцэрлэг зэрэг 20 байгууллага ажилчдын ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс нийт **12.0** сая төгрөгийн цалин илүү олгосон байна.
- Шаамар сумын иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн БНХАУ-ын Манжуур хотод хөдөө аж ахуйн хүлэмжийн аж ахуйтай танилцах, туршлага судлах ажлаар явах зардал 8.0 сая төгрөгийг ИТХ-ын төсвөөс зарцуулсан байна ,
- Санхүүгийн хяналт, аудитын алба, Мандал сумын Баян, Ачит, Бату өрхийн эмнэлгүүд нь нийт **5.8** сая төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

- *Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 8.0 сая төгрөгийг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгөөс Мандал сум авто машины засварын зардалд 9.4 сая төгрөгийг, Хүдэр сум хөрөнгө оруулалтын 10 ажлын санхүүжилтэд 37.6 сая төгрөгийг, Түшиг сум шинэ жилийн арга хэмжээнд 0.8 сая төгрөгийг зэрэг нийт 55.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.*

**3.1.8** Аудитаар УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 4 дэх “Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх”, 5 дахь “Төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах” гэсэн заалтуудыг зөрчин цалингийн зэрэг, шатлал нэмэгдүүлэн нийт **1.3** сая төгрөг олгосон байна. **Үүнд:**

- *Алтанбулаг сумын ЭМТ 0.1 сая төгрөг;*
- *Зүүнбүрэн сумын ЕБСургууль 0.3 сая төгрөг;*
- *Түнхэл тосгоны захирагчийн алба 0.4 сая төгрөг;*
- *Шаамар сумын цэцэрлэг 0.3 сая төгрөгийг ажилтнуудын цалингийн зэргийг нэмэгдүүлэхэд зарцуулсан бол Мандал сумын 3-р ЕБСургууль 0.2 сая төгрөгийг цалингийн шатлалыг нэмэгдүүлэхэд зарцуулсан байна.*

**3.1.9** Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд “УИХ-ын 67 дугаар тогтоолын дагуу 2017 онд төрийн албан хаагчид 300.0 мянган төгрөгийн урамшуулал олгох асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч нарт даалгав” гэж заасныг зөрчин аймгийн хэмжээнд нийт 49 байгууллага сахилгын шийтгэлтэй албан хаагчдад төрөөс олгох урамшуулал олгох, тогтоосон хэмжээнээс илүү тооцож олгосон зэргээр нийт **43.4** сая төгрөгийг зарцуулсан байна.

**3.2 Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 71.0 хувь нь эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.**

**3.2.1** 2017 онд Сэлэнгэ аймгийн ОНХС-д оны эхний үлдэгдлээс 134.5 сая төгрөгийн, улсын төсвөөс 2,139.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, нийт 2,274.1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс эх үүсвэр бүрэн төвлөрч, 33.2 хувийг буюу 757.7 сая төгрөгийг аймгийн, 66.8 хувийг буюу 1,519.9 сая төгрөгийг сумдад олгохоор хуваарилан батлан санхүүжилтийг бүрэн олгосон байна.

**3.2.2** Тайлант онд аймгийн ОНХС-д 118.6 сая төгрөгийн төсөвтэй 2 ажлыг шилжих хөрөнгө оруулалтаар, 585.6 сая төгрөгийн төсөвтэй 6 ажлыг шинээр эхлэх хөрөнгө оруулалтаар, 53.5 сая төгрөгийн төсөвтэй 2 ажлыг төсөл, арга хэмжээний зардлаар зэрэг нийт 757.7 сая төгрөгийн 10 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталснаас **СЭА-2018/01/СТА-ТЕЗ** **хуудас17**

шинээр эхлэх 48.5 сая төгрөгийн “Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт тоног төхөөрөмж авах” ажил хугацаа оройтсоноос шалтгаалан дараа онд шилжин, 674.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 35.0 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.

**3.2.3** Аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн 33 дугаар “Сэлэнгэ аймгийн 2017 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор урьд оноос шилжих 16 төсөл, арга хэмжээнд 307.7 сая төгрөгийн, шинээр эхлэх 53 төсөл, арга хэмжээнд 1,379.7 сая төгрөгийн нийт **1,687.5** сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг баталсан байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн төсөл арга хэмжээний хувьд 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Баянгол сумын Хүүхэд хөгжлийн ордны барилга угсралт”-ын ажлыг аймгийн ИТХ-ын 2017 оны 11 сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолоор “Баянгол сумын шинэ соёлын төвийн зураг төсвийн ажил” гэж өөрчилснөөс хугацаа оройтон төсвийн жилд багтаж хэрэгжээгүй бол бусад 15 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 282.1 сая төгрөгийг олгож, гүйцэтгэсэн байна.

**3.2.4** Шинээр эхлүүлэх 53 төсөл арга хэмжээнээс 3.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүхбаатар сумын яндан буулгах ажил нь батлагдсан төсөвтөө багтаагүйгээс хэрэгжээгүй бол бусад 52 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 1,366.1 сая төгрөгийг зарцуулж, аймгийн төрийн санд байрших орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцааны дансанд 35.6 сая төгрөгийг шилжүүлэн, төсвийн гүйцэтгэл цэвэр дүнгээр **1,648.2** сая төгрөгөөр буюу 97.7 хувийн гүйцэтгэлтэй гарч, 16.3 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.

**3.2.5** Хүдэр сум нь 2017 онд сумын хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтад тусгагдаж, ИТХ-аар батлагдаагүй **20.0** сая төгрөгийн үнэтэй Зил-130 машиныг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24.4, 41.2.2-дахь заалтууд, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**3.2.6** Аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 33 дугаар “Сэлэнгэ аймгийн 2017 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор урьд оноос шилжих 6 төсөл, арга хэмжээнд 221.1 сая төгрөгийн, шинээр эхлэх 21 төсөл, арга хэмжээнд 720.5 сая төгрөгийн зэрэг нийт **941.6** сая төгрөгийн замын сангийн хөрөнгө оруулалтын зардлыг баталсан байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 6 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 467.6 сая төгрөг зарцуулсан бол шинээр эхлүүлсэн төсөл, арга хэмжээнээс 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Мандал сумын авто замын зураг төсөв хийгдээгүйгээс дараа онд шилжин, бусад 20 төсөл арга хэмжээнд 693.4 сая төгрөгийг зарцуулж, нийт **911.7** сая

төгрөгийн буюу 96.8 хувийн гүйцэтгэлтэй, 9.9 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.

**3.2.7** Тайлант онд Сум хөгжүүлэх сангийн дансанд 1,718.2 сая төгрөгийн зээл, хүүгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 675.7 сая төгрөг төвлөрч, зээлийн эх үүсвэрийн бүрдэлтээс хамаарч 459.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

#### Хүснэгт № 7

№	Сумдын нэр	Орлого /сая.төг/		Зардал /сая.төг/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Цагааннуур	65.0	35.5	65.0	0
2	Түшиг	108.3	26.4	108.3	0
3	Зүүнбүрэн сум	139.0	19.2	139.0	21.2
4	Сүхбаатар сум	32.6	123.0	32.6	32.5
5	Алтанбулаг	78.4	50.0	78.4	28
6	Орхон	211.2	40.3	211.2	75
7	Орхонтуул	0	0	0	0
8	Баянгол	80.8	45.0	80.8	77
9	Сант	62.1	52.3	62.1	47.5
10	Ерөө	77	25.3	77	0
11	Мандал	147.8	68.5	147.8	0
12	Хүдэр	87.1	31.5	87.1	43.2
13	Хушаат	159.6	13.4	159.6	0
14	Баруунбүрэн	141.1	39.1	141.1	42
15	Жавхлант	41.2	24.6	41.2	0
16	Шаамар	201	17.9	201	8.5
17	Сайхан	86.0	63.7	86.0	85.0
<b>Нийт дүн</b>		<b>1,718.2</b>	<b>675.7</b>	<b>1,718.2</b>	<b>459.9</b>

**3.2.8** Жилийн эцсийн байдлаар Сум хөгжүүлэх сангийн зээлийн 4,843.6 сая төгрөгийн, хүүгийн авлагын 237.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсанаас 2011-2016 оны хооронд олгосон зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэл **3,398.7** сая төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн авлага **206.1** сая төгрөг байгаа нь нийт зээл, хүүгийн авлагын 71.0 хувийг эзэлж байна. /Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт-4-д үзүүлэв/

**3.3 Засгийн газрын нөөц сангаас аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 220.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгээгүй байна.**

**3.3.1** Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн харилцах дансны эхний үлдэгдэл 258.4 сая төгрөг байсан бол тайлант онд 3,657.2 сая төгрөгийн орлого төвлөрч, 3,915.6 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулан, оны эцэст 200 төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй

тайлагнагдсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдсэн байна. **Үүнд:**

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,041.6 сая төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 220.2 сая төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 759.1 сая төгрөг;
- Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө, бусад эх үүсвэрээс 636.3 сая төгрөг;
- Урьд оны үлдэгдэлээс 258.4 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

**3.3.2** Тайлант онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 3,915.6 сая төгрөгийг зарцуулсан ба нийт зарлагын 64.5 хувийг урсгал зардалд, 26.7 хувийг хөрөнгийн зардалд, 8.8 хувийг урсгал шилжүүлгийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг **Хүснэгт 8-д** харуулбал: /сая төгрөгөөр/

Зардлын зүйл	Орон нутгийн байгууллага	ТЗШБайгууллага	Нийт зардал
Цалин, НДШ-ийн зардал	27.3	12.7	40.0
Эд хогшил худалдан авах болон урсгал засварын зардал	37.1	60.9	98.0
Хангамж бараа материалын зардал	50.9	106.1	157.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190.1	224.7	414.8
Нормативт зардал	3.2	496.6	499.8
Бусад бараа үйлчилгээний зардал	1,040.2	273.7	1,313.9
НД-н тэтгэвэр, тэтгэмж, ХОНТ, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал	2.3	48.6	50.9
Хөрөнгийн зардал	1,020.3	27.3	1,047.6
Төвлөрүүлэх шилжүүлэг	261.6	32.0	293.6
<b>Нийт дүн</b>	<b>2,633.0</b>	<b>1,282.6</b>	<b>3,915.6</b>

**3.3.3** Тайлант онд Засгийн газрын нөөц сангаас төрийн үйлчилгээнд ашиглагдаж буй техник хэрэгсэл, автомашины хэвийн ажиллагаа, бэлэн байдлыг хангах зориулалтаар **220.0** сая төгрөгийг аймгийн ЗДТГ-т нэмэлт санхүүжилт хэлбэрээр олгосныг орон нутгийн төсвийн 5 /*аймгийн болон Сайхан, Хүдэр, Зүүнбүрэн сумдын ЗДТГ, Номын сан*/, улсын төсвийн 3 /*Шаамар сумын МСҮТөв, ГИХГ-ын Хойд бүс дэх газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг*/ байгууллагад автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүрэн тоноглогдсон 200 ширхэг өвчтөний ор худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Шууд худалдан авах босго үнээс давсан дээрх хөрөнгүүдийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар бус шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн, орон нутгийн ТЕЗ-д хуваарилсан хөрөнгийг улсын

төсвийн байгууллагуудад зарцуулсан зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 8 дугаар зүйлийн 8.7.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтууд, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг зөрчиж байна.

## **Аудитын дүгнэлт**

**Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Сангийн яамнаас хянаж, УИХ-аар батлагдсан ус ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.
- Сангийн яамаар хянагдаж, УИХ-аар батлагдсан аймгийн ИТХ-ын урсгал зардлыг аймагт 87.9 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.
- Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан зайлшгүй нөхцөл, шаардлага үүсээгүй байхад аймаг, сумдын төсөвт 3-6 удаа тодотгол хийж, орон нутгийн төсвийн орлого, зарлагыг 5,252.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
- Аймаг ус ашигласны төлбөрийн орлогыг, зарим сумд хог хаягдлын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх нөөц боломжийг бүрэн ашиглаагүй байна.
- Орон нутгийн өмчийг ашиглан халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниудаас 138.7 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэх нөөц боломж байна.
- Аймгийн төсөвт төвлөрөх орлогыг холбогдох хууль, эрхийн актуудад нийцүүлэн бүрэн төвлөрүүлээгүй байна.
- Орон нутгийн төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад батлагдсан төсвийг зориулалт бусаар, үрэлгэн зарцуулах, холбогдох хууль, тогтоомжийг зөрчин хөрөнгө зарцуулах зэрэг их хэмжээний зөрчил оршиж байна.
- Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 71.0 хувь нь эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.
- Засгийн газрын нөөц сангаас аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 220.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгээгүй байна.

**Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:**

Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан **77,044.7** сая төгрөгийн орлого, **76,839.4** сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ТЕЗ, Засаг дарга Ш.Оргил,  
ЗДТГ-ын СТСХ-ийн дарга М.Нарантуяа нарт:

- Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан орон нутгийн төсөвт зайлшгүй тодотгол хийх нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд төсөвт тодотгол хийж, хөрөнгө оруулалтын болон урсгал зардлуудыг санхүүжүүлэхгүй байх.
- Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхгүй байх.
- Улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардал, нэн тэргүүний ач холбогдолгүй автомашин, техник тоног төхөөрөмж бэлтгэх, хөшөө дурсгал босгох зэрэг төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх.
- Төсвийн тухай хуулийн 23-р зүйлийн дагуу улс, аймгийн төсвийн орлогыг суманд төвлөрүүлэн зарцуулж буй зөрчлийг таслан зогсоох.
- УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг мөрдөж, 2019 он хүртэл цалингийн санг царцаах бодлого барьж, цалингийн зэрэг, шатлал нэмэгдүүлэхгүй байхыг төсвийн захирагч нарт үүрэг болгох.
- Төсвийн захирагч нарыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарцуулалтад оршиж буй зөрчлийг арилгах.
- Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн барагдуулалтыг эрчимжүүлэх талаар дорвитой арга хэмжээ зохион байгуулж, үр дүнд хүрэх.
- Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгож, үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АУДИТОР

А.ДАШБАТ

Ц.УРТНАСАН